



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Булган сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: АРА-2021/17/СТА-ТТЗ

<p>Хаяг: Архангай аймаг, Эрдэнэбулган сум. Аймгийн ЗДТГ-ын байр “А” корпус, 3 давхар зүүн жигүүр.</p> <p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>2020 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Д.Уламбаяр Утас: 70333141 Цахим хаяг: UlambayarD@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Т.Байгалмаа Утас: 70332860 Цахим хаяг: BaigalmaaT@audit.gov.mn</p> <p>Аудитор: В.Цогжаргал Утас: Цахим хаяг: TsogjargalB@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

Аудитын код: АРА-2021/15/СТА-ТТЗ.....	0
1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	9
3. Аудитын тайлан	10
3.1. Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	11
3.5.1 Мөнгөн хөрөнгө	11
3.5.3 Авлага.....	12
3.5.6 Бараа материал	12
3.5.7 Үндсэн хөрөнгө.....	13
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо.....	14
3.5.10 Орлогын данс	14
3.5.11 Зардлын данс.....	14
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	15
3.7 Шилэн дансны мэдээлэл	18
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	18
3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	19
3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	20
4. Менежментийн захидал.....	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч

1. Аудитын гэрчилгээ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65139 Архангай аймаг, Эрдэнэбулган сум, 2-р баг,
Утас/Факс: (976) 7033 3141, И-мэйл: arkhangai@audit.gov.mn
Вэб сайт: www.audit.mn

2021.03.31 № 145

танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Булган сумын ТЕЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгөл/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын ТЕЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 21 зорилтын хүрээнд 100 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 78.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсөв захирагч нь нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.УЛАМБАЯР



2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	384,842.4	776,009.3
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	28,309.4	401,809.7
33	АВЛАГА	274,319.6	266,895.6
35	БАРАА МАТЕРИАЛ	82,213.4	107,304.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,075,187.3	4,055,818.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,075,187.3	4,055,818.5
39200	Биет хөрөнгө	3,990,965.3	3,972,046.5
39300	Биет бус хөрөнгө	84,222.0	83,772.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,460,029.7	4,831,827.8
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,460,029.7	4,831,827.8
51	Засгийн газрын хувь оролцоо	4,460,029.7	4,831,827.8
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,247,652.6	1,247,652.6
51200	Хуримтлагдсан үр дүн	2,103,273.7	2,475,071.7
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,109,103.4	1,109,103.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,460,029.7	4,831,827.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,735,789.7	2,448,327.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	88,772.1	434,291.8
110	Орлогын албан татвар	29,064.6	43,787.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	29,064.6	43,787.2
113	Хөрөнгийн албан татвар	2,879.7	2,430.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	56,827.8	388,074.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	820,996.4	289,941.6
120	Нийтлэг татварын бус орлого	820,996.4	289,941.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,826,021.2	1,724,094.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,024,244.8	2,010,063.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,024,244.8	2,010,063.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,668,762.6	1,912,799.2

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,057,906.8	1,171,657.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	132,223.7	168,368.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,843.2	87,013.8
2104	Хангамж, бараа материалын зардал	56,875.4	71,260.4
2105	Нормативт зардал	90,068.5	92,870.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,116.2	12,623.8
2107	Томилолт, зочны зардал	7,111.3	3,253.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,372.6	21,688.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	225,244.7	284,063.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	355,482.2	97,264.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	711,544.9	438,264.4
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	49,699.6	66,466.4
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	661,845.3	371,798.0

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,952,431.4	2,190,626.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	88,772.1	434,291.8
110	Орлогын албан татвар	29,064.6	43,787.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	29,064.6	43,787.2
113	Хөрөнгийн албан татвар	2,879.7	2,430.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	56,827.8	388,074.6
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	10,381.8	7,110.8
1181	Газрын төлбөр	14,640.0	2,281.7
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	31,806.0	378,682.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	37,638.1	32,239.7
120	Нийтлэг татварын бус орлого	37,638.1	32,239.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,826,021.2	1,724,094.4
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,835,921.3	1,735,981.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,835,921.3	1,735,981.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,480,222.4	1,638,581.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,057,906.8	1,170,657.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	132,223.7	169,368.5

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,755.8	91,755.8
2104	Хангамж, бараа материалын зардал	58,238.9	75,607.7
2105	Нормативт зардал	90,248.2	59,059.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,544.0	13,124.8
2107	Томилолт, зочны зардал	7,111.3	3,253.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,717.4	26,154.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,476.3	29,600.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	355,698.9	97,399.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	116,510.1	454,644.8
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	77,271.5	74,144.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	77,271.5	74,144.4
2200	Дотоод эх үүсвэрээр	77,271.5	74,144.4
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-77,271.5	-74,144.4
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-19,650.0	-7,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	19,650.0	7,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	19,588.6	373,500.3
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,720.8	28,309.4
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	28,309.4	401,809.7

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,798,184.4	3,798,184.4
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,798,184.4	3,798,184.4
9	Тайлант үеийн үр дүн	661,845.3	661,845.3
10	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,460,029.7	4,460,029.7
11	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,460,029.7	4,460,029.7
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,460,029.7	4,460,029.7
19	Тайлант үеийн үр дүн	371,798.0	371,798.0

20	2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	4,831,827.8	4,831,827.8
----	---------------------------------------	-------------	-------------

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,891,758.1	1,723,209.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,744,336.3	1,668,046.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,713,852.3	1,642,216.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,215,546.6	1,170,657.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	169,368.6	169,368.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	96,322.1	91,755.8
2104	Хангамж, бараа материалын зардал	71,586.4	68,780.2
2105	Нормативт зардал	72,302.7	55,201.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,290.0	16,470.5
2107	Томилолт, зочны зардал	3,631.8	3,253.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,005.4	30,204.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,798.7	36,525.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,484.0	25,829.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,484.0	25,829.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	66,221.8	48,163.1
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	81,200.0	7,000.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,891,758.1	1,740,742.9
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,161,447.9	1,086,028.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	584,301.5	600,575.3
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	28,223.2	28,265.9
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	117,785.5	25,873.7
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	11,340.6
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	28,874.2
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	6	6
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	113	113
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	428	428
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	250	250
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	178	178
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	113	113

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	22,346.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	22,346.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,346.9
2104	Хангамж, бараа материалын зардал	10,367.5
2105	Нормативт зардал	3,858.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,036.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,085.0
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	22,346.9
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	22,346.9

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Булган сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч Ц.Төрхүү танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн сум хөгжүүлэх сангийн авлагыг бууруулахад тодорхой арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 3 дугаар сарын 20-аас 2021 оны 3 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 3 дугаар сарын 29-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор В.Цогжаргал гүйцэтгэв.

Булган сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 3 дугаар сарын 5-ний өдөр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Булган сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн нь “Сумын Иргэдийн хурал, засаг дарга, байгууллага иргэдийн хэвийн ажиллах нөхцөлийг баталгаатай ханган төрийн үйлчилгээг чанартай, шуурхай хүргэж орон нутагтаа сайн сайхан, эрүүл аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэн улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүйгээр иргэддээ үнэнч шударга үйлчлэн үйл ажиллагаагаараа үргэлж манлайлсан аймгийн тэргүүний Тамгын газар байх” эрхэм зорилго тавьж дараах гол зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

- ✓ Сумын төрийн удирдлагын хэвийн үйл ажиллагааг хангаж шийдвэр боловсруулан гаргахад дэмжлэг үзүүлэх
- ✓ Сумын төрийн захиргааг бүх талаар үр дүнтэй үр нөлөөтэй удирдах, стратегийн зорилтын дагуу удирдлага зохион байгуулалтаар хангах замаар сумын иргэдэд нарийн мэргэшсэн тогтвортой чадварлаг төрийн албадаар үйлчлэх
- ✓ Сумын төрийн байгууллагын хязгаарлагдмал нөөцийг ханган ашиглах

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Булган сумын Төсвийн ерөнхийлөн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн

баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Булган сумын удирдлагын байгууллагууд нь санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байгаа нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, НББ-ийн тухай хууль тогтоомж зөрчигдөх, санхүүгийн тайланг бэлтгэхэд баримтлах зарчим алдагдах зэрэг үр дагавартай байна.

Булган сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна. Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавьж ажиллах зөвлөмжийг хүргүүлээ.

Булган сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад аудитаар илэрсэн алдаа зөрчлийг эс тооцвол дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,077,919,843.2 мянган төгрөгийн 1 хувь буюу **20,779.2** мянган төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 28,309.4 мянга, эцсийн үлдэгдэл 401,809.7 мянган төгрөг болж 373,500.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт(-)
Төрийн сангийн харилцах	28,309.4	401,809.7	373,500.3
НИЙТ МӨНГӨН ХӨРӨНГИЙН ДҮН	28,309.4	401,809.7	373,500.3
Үүнээс, байгууллагын төрлөөр:			
Сум хөгжүүлэх сан	3,183.9	10,815.4	7,631.5
Орон нутгийн ерөнхий орлого	16,968.8	372,935.6	355,966.8
Орон нутгийн хөгжлийн сан	8,156.7	18,058.7	9,902.0
НИЙТ МӨНГӨН ХӨРӨНГИЙН ДҮН	28,309.4	401,809.7	373,500.3

Эх сурвалж: Булган сумын ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 373,500.3 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн

хөгжлийн сангаас санхүүжүүлэхээр төлөвлөсөн Зуунмод багийн зам засварын ажил огт хэрэгжээгүйгээс 18,058.7 мянган төгрөгийн санхүүжилт олгогдоогүй, мөн сум хөгжүүлэх сан 10,815.4 мянган төгрөг, орон нутгийн ерөнхий орлогын данс 372,935.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаатай холбоотой байна.

Орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл нь давсан орлого 372,240.5 мянга, орон нутгийн удирдлагын байгууллагын төвлөрүүлэх шилжүүлэг 695.1 мянган төгрөгөөс бүрдэж байна. Нийт давсан орлогын 93.5% буюу 347,925.7 мянган төгрөг нь байгалийн ургамал ашигласны төлбөр буюу самрын орлого байна.

3.5.2 Авлага

Авлагын данс 266,895.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Сум хөгжүүлэх сангаас 70 төсөл хэрэгжүүлэгчдэд олгосон зээлийн авлага байна.

3.5.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 82,213.4 мянга, эцсийн үлдэгдэл 107,303.9 мянган төгрөг болж, 25,090.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Бараа материалын үлдэгдэл /мян.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Эм боох материал	0.0	2,277.0	2,277.0
Бичиг хэргийн материал	300.0	700.0	400.0
Аж ахуйн материал	69,594.2	87,090.9	17,496.7
Түлш шатах тослох материал	4,884.0	9,626.0	4,742.0
Хүнсний материал	705.2	0.0	(705.2)
Мал амьтад	6,730.0	7,610.0	880.0
Дүн	82,213.4	107,303.9	25,090.5
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Засаг даргын тамгын газар	14,026.3	14,026.3	0.0
Ерөнхий боловсролын сургууль	45,069.2	58,877.4	13,808.2
Эрүүл мэндийн төв	5,058.1	4,566.0	(492.1)
Соёлын төв	4,050.8	4,050.8	0.0
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	163.9	583.9	420.0
Хүүхдийн цэцэрлэг	13,845.1	25,199.5	11,354.4
Дүн	82,213.4	107,303.9	25,090.5

Эх сурвалж: Булган сумын ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт бараа материалын 54.8 хувь буюу 58,877.4 мянган төгрөгийг ерөнхий боловсролын сургууль, 23.5 хувь буюу 25,199.5 мянган төгрөгийг Хүүхдийн цэцэрлэг, 13.1 хувь буюу 14,026.3 мянган төгрөгийг ЗДТГ, 4.2 хувь буюу 4,566.0 мянган төгрөгийг ЭМТ, 3.8 хувь буюу 4,050.8 мянган төгрөгийг Соёлын төв, 0.6 хувь буюу 583.9 мянган төгрөгийг ИТХ эзэлж байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 252,001.0 мянган төгрөг, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 34,077.1 мянган төгрөг, шилжүүлэн авсан 9,498.0 мянган төгрөг нийт 295,576.1 мянган төгрөгөөр нэмэгдэж үйл ажиллагаанд зарцуулсан 266,348.0 мянган төгрөг, шилжүүлсэн 4,137.5 мянган төгрөг нийт 270,485.5 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

2020 оны ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалтай холбоотой дараах зөрчил илэрсэн байна.

- Булган сумын ЭМТ- Бараа материалын тайланд 6,475.7 мянган төгрөгийн эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгслийг бараа материалын тайланд тусгаагүй байсныг аудитын явцад залруулан санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгүүлсэн.
- Булган сумын ЕБС-Тайлант онд бүртгэгдсэн 7,610.0 мянган төгрөгийн 188 ширхэг малын нэг тус бүрийн үнийг малын зах зээлийн дундаж үнээс 2-3 дахин багаар үнэлж хөрөнгө бүртгэлд тусгасан зөрчилд зөвлөмж хүргүүлээ.
- Булган сумын ЗДТГ-12,046.4 мянган төгрөгийн бараа материалыг шууд зардлаар бүртгэж тайлагнасныг бараа материалын тодруулга тайланд залрууллаа.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 4,075,187.3 мянга, эцсийн үлдэгдэл 4,055,818.5 мянган төгрөг болж, 19,368.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мян. төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	3,990,965.3	3,972,046.5	(18,918.8)
Биет бус хөрөнгө	84,222.0	83,772.0	(450.0)
Дүн	4,075,187.3	4,055,818.5	(19,368.8)
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Засаг даргын тамгын газар	629,319.3	621,748.9	(7,570.4)
Ерөнхий боловсролын сургууль	1,898,013.7	1,867,943.7	(30,070.0)
Эрүүл мэндийн төв	481,123.1	475,451.6	(5,671.5)
Соёлын төв	19,229.3	24,281.1	5,051.8
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	161.1	4,160.5	3,999.4
Хүүхдийн цэцэрлэг	1,047,340.8	1,062,232.7	14,891.9
Дүн	4,075,187.3	4,055,818.5	(19,368.8)

Эх сурвалж: Булган сумын ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт үндсэн хөрөнгийн 46.1 хувь буюу 1,867,943.7 мянган төгрөгийг ерөнхий боловсролын сургууль, 26.2 хувь буюу 1,062,232.7 мянган төгрөгийг хүүхдийн цэцэрлэг, 15.4 хувь буюу 621,748.9 мянган төгрөгийг ЗДТГ, 11.7 хувь буюу 475,451.6 мянган төгрөгийг Эрүүл мэндийн төв, 0.6 хувь буюу 24,281.1 мянган төгрөгийг Соёлын төв тус тус эзэлж байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 25,981.3 мянган төгрөг, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 223,198.3 мянган төгрөг, шилжүүлэн авсан 43,617.2 мянган төгрөг нийт 292,796.8 мянган төгрөгөөр нэмэгдэж акталж устгасан 869.2 мянган төгрөг, шилжүүлсэн 81,449.6 мянган төгрөг нийт 82,318.8 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

2020 оны ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар үндсэн хөрөнгөтэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна.

- Булган сумын Хүүхдийн цэцэрлэг- Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангаас хөөн шалгахад элэгдлээрээ анхны өртөгөө бүрэн нөхсөн нийт 32,756.8 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

- Булган сумын ЭМТ-Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангаас хөөн шалгахад элэгдлээрээ анхны өртөгөө бүрэн нөхсөн нийт 39,491.0 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчилд зөвлөмж хүргүүлээ.
- Булган сумын ЕБС-2,528.7 мянган төгрөгийн үнэ төлбөргүй олгосон болон түрээсийн сурах бичгийг бүртгэл тайланд тусгаагүй зөрчилд зөвлөмж хүргүүлээ
- Булган сумын ЗДТГ-Байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд ашиглалтын хугацаа дуусч элэгдлээ бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй 255,935.8 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчилд зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.

3.5.5 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4,460,029.8 мянга, эцсийн үлдэгдэл 4,831,827.8 мянган төгрөг болж, 371,798.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Засгийн газрын хувь оролцоо /мян. төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/
Засгийн газрын оруулсан капитал	1,247,652.6	1,247,652.6	0.0
Хуримтлагдсан үр дүн	2,103,273.7	2,475,071.7	371,798.0
Өмнөх үеийн үр дүн	1,441,428.4	2,103,273.7	661,845.3
Тайлант үеийн үр дүн	661,845.3	371,798.0	(290,047.3)
Хөрөнгийн дахин үнэлгээний	1,109,103.4	1,109,103.4	0.0
Дүн	4,460,029.8	4,831,827.8	371,798.0

Эх сурвалж: Булган сумын ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүн болох 371,798.0 мянган төгрөгөөр өсч тайлагнагдсан байна.

3.5.6 Орлогын данс

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар 434,291.8 мянган төгрөгийн татварын орлого, 289,941.6 мянган төгрөгийн татварын бус орлого, 1,724,094.4 мянган төгрөгийн тусламж санхүүжилтийн орлого нийт 2,448,327.9 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлого тайлагнагдсан байна. Тусламж санхүүжилтийн орлогын 1,157,597.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 22,346.9 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн орлогоос, 515,884.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 28,265.9 мянган төгрөгийг нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжүүлсэн байна.

3.5.7 Зардлын данс

Санхүүгийн нэгтгэсэн тайланд үйл ажиллагааны зардал 2,010,063.4 мянган төгрөг, үйл ажиллагааны бус зардал 66,466.4 мянган төгрөг, нийт 2,076,529.8 мянган төгрөгийн зардал тайлагнасан байна. Үйл ажиллагааны нийт үр дүн өмнөх оноос 290,047.3 мянган төгрөгөөр буурсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого буурсантай холбоотой байна.

Тайлант онд 398,142.4 мянган төгрөгийн давхардсан гүйлгээг устгах бичилт хийж тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт:

2020 оны ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар зардлын данстай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна.

- Булган сумын Хүүхдийн цэцэрлэг- Төсвийн зарцуулагдаагүй үлдээгдлээс 1,500.0 мянган төгрөгийн түлш нөөцөлсөн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.
- Булган сумын ЭМТ- Төсөвт зохицуулалт хийлгэлгүйгээр нийт 1107.7 мянган төгрөгийг зориулалт бус зарцуулсан зөрчилд албан шаардлага хүргүүллээ.
- Булган сумын ЭМТ-цалингийн зардлыг давтан тооцоолоход 772.3 мянган төгрөгийн цалинг илүү тооцож олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.
- Булган сумын ЕБС-18,407.7 мянган төгрөгийн и-баримтгүй гүйлгээ хийсэн зөрчилд зөвлөмж хүргүүллээ.
- Булган сумын ЗДТГ-Сумын засаг даргын орлогч даргаар ажиллаж байсан Г.Ганбаярт сумын ИТХ-ын тогтоолыг үндэслэн засаг даргыг хавсран ажилласны нэмэгдэл 3,228.7 мянган төгрөгийг, архив бичиг хэргийн ажилтан Ц.Уртнасанд 188.8 мянган төгрөгийн цалинг илүү тооцож олгосон нийт 3,417.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Булган сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны орон нутгийн ерөнхий орлогыг 65,764.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, Аймгийн санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүргүүлсэн орлогын төсвийн төслийг Сумын ИТХ-ийн 2019 оны 12 сарын 06-ны өдрийн 09 тоот тогтоолоор 427.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 66,191.0 мянган төгрөгөөр анх баталсан байна.

Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 09 дугаар сарын 25-ны өдрийн 05 тоот тогтоолоор сумын орон нутгийн орлогын төлөвлөгөөг 68,417.3 мянган төгрөгөөр тодотгон баталж, гүйцэтгэлээр 441,157.8 мянган төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлж, төлөвлөгөөг 640.1 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 5. Төвлөрүүлэх орлого /мян.төгрөг/

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үйл ажиллагааны орлого	960.0	1,260.0	300.0	
2	Шууд бус орлого	8,320.0	21,327.2	13,007.2	
3	Хадгаламжийн хүүгийн орлого	13,300.0	19,167.0	5,867.0	
4	Үл хөдлөх хөрөнгө борлуулсаны орлого	150.0	2,033.0	1,883.0	
5	Бууны татварын орлого	2,640.0	2,430.0	(210.0)	
6	Улсын тэмдэгийн хураамжийн орлого	2,760.0	1,548.8	(1,211.2)	
7	Газрын төлбөр	0.0	488.5	488.5	
8	Газрын дуудлага худалдааны орлого	6,666.0	1,793.2	(4,872.8)	

9	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1,250.0	2,240.0	990.0
10	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	2,600.0	3,321.9	721.9
11	Байгалийн ургамал ашигласны төлбөр	84.0	348,009.7	347,925.7
13	Ойн нөөц ашигласны төлбөр	28,891.3	30,308.5	1,417.2
14	Ан амьтаны нөөц ашигласны төлбөр	96.0	364.0	268.0
15	Төсөвт байгууллагын өөрийн орлого	500.0	500.0	0.0
16	Хүү торгуулийн орлого	300.0	4,542.0	4,242.0
17	Нэр заагдаагүй бусад орлого	400.0	1,824.0	1,424.0
Дүн		68,917.3	441,157.8	372,240.5

Орон нутгийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ давж биелсэн боловч дараах 3 нэр төрлийн орлого 6,294.0 мянган төгрөгөөр тасарсан байна. Үүнд:

1. Төлөвлөгөө батлагдсаны дараа зарим ашиглалтгүй галт зэвсгийг бүртгэлээс хассанаас шалтгаалан орлого 210.0 мянган төгрөгөөр
2. Нотариатын орлого буурсантай холбоотой улсын тэмдэгтийн хураамжийн орлого 1,211.2 мянган төгрөгөөр
3. 3 байршилд дуудлага худалдаа зохион байгуулж газар эзэмшүүлэхээр төлөвлөсөн боловч 2 байршлын дуудлага худалдаанд оролцогч байхгүй байсны улмаас газрын дуудлага худалдааны орлого 4,872.8 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Төсвийн төлөвлөлт

Сумын ИТХ-ын анхны болон тодотгосон төсөв батлах тухай тогтоолоор төсвийн ерөнхийлөн захирагчийн нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг дараах байдлаар баталсан байна.

Хүснэгт 6. ИТХ-ын тогтоол /мян.төгрөг/

№	Санхүүжүүлэх эх үүсвэр	Анх баталсан дүн	Тодотгон баталсан дүн	Зөрүү
1	Орон нутгийн ерөнхий орлого	66,191.0	68,417.3	2,226.3
2	Төсөвт байгууллагуудын үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого	92,160.0	92,660.0	500.0
3	Аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	326,203.6	312,061.3	(14,142.3)
4	Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	59,864.4	58,065.1	(1,799.3)
5	Тусгай зориулалтын шилжүүлэг	1,468,133.8	1,339,428.9	(128,704.9)
6	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	5,000.0	16,968.8	11,968.8
7	Урьд оны ОНХС-ийн үлдэгдлээс санхүүжих	7,750.0	8,156.7	406.7
Нийт дүн		2,025,302.8	1,895,758.1	(129,544.7)
Байгууллагын нэр				
1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	57,205.3	57,205.3	0.0
2	Засаг даргын тамгын газар	340,189.3	340,742.1	552.8

3	Орон нутгийн хөгжлийн сан	67,614.4	66,221.8	(1,392.6)
4	Сум хөгжүүлэх сан	82,400.0	82,400.0	0.0
5	Сургуулийн өмнөх боловсрол	312,156.8	262,063.1	(50,093.7)
6	Ерөнхий боловсролын сургууль	723,389.0	645,932.1	(77,456.9)
7	Соёлын төв	72,145.7	72,145.7	0.0
8	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ	370,202.3	369,048.0	(1,154.3)
Нийт дүн		2,025,302.8	1,895,758.1	(129,544.7)

Ноос ноолуур, арьс ширний урамшууллаас орсон орлогын гүйцэтгэлд үндэслэн шууд бус орлогыг нэмж баталсанаас ерөнхий орлогыг 2,226.3 мянга, мөн урьд оны үлдэгдлийг 11,968.8 мянган төгрөгөөр нэмж тодотгосон бол орон нутгийн удирдлагын байгууллагын санхүүгийн дэмжлэгийг 14,142.3 мянга, сумын ОНХС-аас хэрэгжүүлэх ажлын гүйцэтгэлд үндэслэн ОНХС-ийн орлогын шилжүүлгийг 1,799.3 мянга, ковид-19 цар тахалтай холбоотой боловсролын байгууллагын үдийн цай хоолны зардал, ЭМТ-ийн тогтмол зардлаас 128,704.9 мянган төгрөгийг хасаж тодотгосон байна.

Аймгийн ИТХ-ын “Аймгийн 2020 оны төсөвт зохицуулалт хийж тодотгон батлах тухай” 2020 оны 12 сарын 13-ны өдрийн 04 тоот тогтоолоор ЕБС-ийн нийт зардлыг 4,000.0 мянган төгрөгөөр бууруулж 641,932.1 мянган төгрөгөөр баталж сумын нийт зардлыг 1,891,758.1 мянган төгрөгөөр баталсан нь ковид-19 цар тахлын улмаас хэмнэгдэж байгаа сургуулийн хүүхдийн үдийн хоол, цайны зардлын санхүүжилтээс Сангийн яам төсөвт зохицуулалт хийн буцаан татсантай холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 1,891,758.1 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,744,336.3 мянган төгрөгийг урсгал зардалд, 66,221.8 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 81,200.0 мянган төгрөгийг сум хөгжүүлэх сангийн зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,161,447.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 584,301.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 28,223.2 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 92,660.0 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос, 25,125.5 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 16,824.0 мянган төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 67,576.0 мянган төгрөгөөр тасарсан нь сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Туслах үйл ажиллагааны орлого 9,049.7 мянган төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 789.7 мянган төгрөгөөр давсан нь ерөнхий боловсролын сургуулийн халаалтын орлого нэмэгдсэнтэй холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,723,209.3 мянган төгрөг буюу 91.1 хувьтай байгаа нь урсгал зардал 76,290.0 мянган төгрөгөөр хэмнэгдсэн, хөрөнгийн зардал 18,058.7 мянган төгрөг зарцуулагдаагүй, 74,200.0 мянган төгрөгийн сум хөгжүүлэх сангийн зээлийг төлөвлөсөн хэмжээнээс дутуу олгосонтой холбоотой байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсөв захирагчаас 22,309.8 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 37.1 мянган төгрөг нийт 22,346.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж урсгал зардалд зарцуулсан байна.

ОНХС болон СХС-ийн талаар

- ✓ Сумын ИТХ-ын хурлын 2020 оны 09 сарын 25-ны өдрийн 05 тоот тогтоолоор сумын ОНХС-ийн хөрөнгөөр нийт 6 хөтөлбөр, төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр 66,219.4 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.
Гүйцэтгэлээр 5 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж, Зуунмод багийн зам засварын ажил огт хэрэгжээгүйгээс 18,058.7 мянган төгрөгийн санхүүжилт олгогдоогүй байна.
- ✓ Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг 82,400.0 мянга, олгох зээлийг 81,200.0 мянган төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 14,424.0 мянган төгрөгийн үндсэн зээл, 400.0 мянган төгрөгийн хүүгийн орлого төвлөрч, 7,000.0 мянган төгрөгийн зээл олгосон байна.
Нийт авлагыг зээлийн ангиллаар авч үзвэл 177,537.5 мянган төгрөг буюу 66.5 хувь нь хугацаандаа төлөгдөж байгаа хэвийн зээл, 89,358.1 мянган төгрөг буюу 33.5 хувь нь чанаргүй зээл байна.

Аудитаас 89,358.1 мянган төгрөгийн чанаргүй зээлийн үлдэгдлийг бууруулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах зөвлөмж хүргүүлээ.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 155 мэдээллээс 146 мэдээллийг хугацаанд нь, 9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 739.1 мянган төгрөгийн орлоготой холбоотой 103,517.0 мянган төгрөгийн сум хөгжүүлэх сангийн авлагатай холбоотой нийт 2 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 7. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мян.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	2	104,256.0	1	52,497.6	1	51,758.5	75.0
Нийт	2	104,256.0	1	52,497.6	1	51,758.5	75.0

СХС-ийн авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаж байгаа боловч 89,358.1 мянган төгрөгийн чанаргүй зээлийн үлдэгдэлтэй байгаа тул шийдвэрийн

биелэлтийг 50 хувьтай байна гэж үзлээ. Орон нутгийн орлоготой холбоотой зөрчилд өгсөн шийдвэрийн биелэлт бүрэн хангагдсан байна.

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна. Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 8. Санал дүгнэлтийн хэлбэр

№	Байгууллагын нэр	Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр			
		Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамрагдсан	Итгэл үзүүлсэн	Аудитад хамрагдаагүй
1	Засаг даргын тамгын газар	1			
2	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1			
3	Ерөнхий боловсролын сургууль	1			
4	Хүүхдийн цэцэрлэг			1	
5	Эрүүл мэндийн төв	1			
6	Соёлын төв		1		
7	Орон нутгийн хөгжлийн сан		1		
8	Сум хөгжүүлэх сан		1		
	Дүн	4	3	1	

Аудитаас дээрх 4 байгууллагад “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 459,467.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 20,422.1 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 13,284.9 мянган төгрөгийн 6 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 420,070.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 14 зөвлөмж хүргүүлж, 5,689.8 мянган төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоолоо. Үүнийг төсвийн шууд болон ерөнхийлөн захирагчаар ангилан харуулбал:

Нэг. Төсвийн шууд захирагчдын СТА-ын дүнгийн талаар

Төсвийн шууд захирагчдийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт **368,687.9** мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнээс 20,422.1 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 330,712.3 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж, 11,863.7 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 5,689.8 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна. Үүнд:

Хүснэгт 9. ТШЗ-ийн зөрчлийн нэгтгэл /мян.төг/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн		Үүнээс:						
		Тоо	Дүн	Зөвлөмж		Албан шаардлага		Акт		Залруулсан
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	Засаг даргын Тамгын газар	6	271,399.7	3	255,935.8			2	3,417.5	12,046.4
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1	0.0	1	0.0					
3	Ерөнхий боловсролын сургууль	5	2,528.7	4	2,528.7	1	0.0			
4	Соёлын төв	1	3,742.4			1	3,742.4			
5	Эрүүл мэндийн төв	6	54,860.3	2	39,491.0	2	8,121.3	1	772.3	6,475.7
6	Хүүхдийн цэцэрлэг	5	36,156.8	2	32,756.8	1	0.0	1	1,500.0	1,900.0

ДҮН	24	368,687.9	12	330,712.3	5	11,863.7	4	5,689.8	20,422.1
------------	-----------	------------------	-----------	------------------	----------	-----------------	----------	----------------	-----------------

Хоёр. Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн СТА-ын дүнгийн талаар

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 90,779.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнээс 89,358.1 мянган төгрөгийн сум хөгжүүлэх сангийн авлагатай холбоотой болон шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан зөрчилд зөвлөмж хүргүүлж, 1,421.2 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

Хүснэгт 10. ТЕЗ-ийн зөрчлийн нэгтгэл /мян.төг/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн		Үүнээс:			
		Тоо	Дүн	Зөвлөмж		Албан шаардлага	
				Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Нэгтгэсэн тайлан	2	1,421.2	1		1	1,421.2
2	СХС	1	89,358.1	1	89,358.1		
	ДҮН	3	90,779.3	2	89,358.1	1	1,421.2

Сумын ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

1. Орон нутгийн төсвийн 2 нэр төрлийн орлогын төлөвлөгөө 1,421.2 мянган төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасны дагуу зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүллээ.

Сумын ерөнхийлөн захирагчид СХС-ийн 89,358.1 мянган авлагатай холбоотой өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тухайн байгууллагын хувьд балансын дараах үйл явцад хамааруулах асуудал гараагүй бөгөөд дараагийн аудитаар илэрсэн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргасан эсэхийг авч үзэх нь зүйтэй байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. *Балансын данстай холбоотой асуудал*

- 1.1. Илрүүлэлт: Сум хөгжүүлэх сангаас олгосон 89,358.1 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Засгийн газрын 2016 оны 153-р тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих” журмыг зөрчсөн байна.
- 1.2. Эрсдэл: Сум хөгжүүлэх сангийн орлогын бүрдүүлэлт, эх үүсвэр боломжит хэмжээнд төвлөрөхгүй байх, зарцуулалт үр дүнгүй болох улмаар найдваргүй авлага үүсэх эрсдэлийг бий болгож болзошгүй цаашилбал сангийн хөрөнгийн эх үүсвэр дутагдаж, зээлийн ашиглалтаас бий болох үр нөлөө буурах болно.
- 1.3. Өгсөн зөвлөмж Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг батлагдсан төлөвлөгөөний дагуу бүрэн биелүүлэхэд цаг алдалгүй тодорхой арга хэмжээ авч, Засгийн газрын 2016 оны 153-р тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих” журмыг мөрдөж ажиллах

2. *Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрхзүйн асуудал*

- 2.1. Илрүүлэлт: Тайлант хугацаанд 155 мэдээ мэдээлэл байршуулахаас 146 мэдээллийг хугацаанд нь 9 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.
- 2.2. Эрсдэл: Хуулийн хэрэгжилт хангагдахгүй байх.
- 2.3. Өгсөн зөвлөмж Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.1-6.4, 6.10 дахь заалтуудыг мөрдөж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 10 дугаар сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАН		
Бэлтгэсэн:	Аудитор	В.Цогжаргал
Анхан шатанд хянасан:	Аудитын менежер	Т.Байгалмаа
Хоёр дахь шатанд хянасан:	Тэргүүлэх аудитор	Д.Уламбаяр

Хавсралт

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Сумдын ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит	Аудитын код:
2021 он			АРА-2021/17/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Булган сумын ТЕЗ-ийн 2020 оны СТА		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
1	Орон нутгийн төсвийн 2 нэр төрлийн орлогын төлөвлөгөө 1,421.2 мянган төгрөгөөр тасарсан байна.	1,421.2	Албан шаардлага өгөх	Засаг дарга, САД	Ц.Төрхүү Г.Отгонцэцэг
2	Сум хөгжүүлэх сангаас олгосон 89,358.1 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдэлтэй байна	89,358.1	Зөвлөмж өгөх	Засаг дарга, САД	Ц.Төрхүү Г.Отгонцэцэг
3	Тайлант хугацаанд 155 мэдээ мэдээлэл байршуулахаас 146 мэдээллийг хугацаанд нь 9 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна	0.0	Зөвлөмж өгөх	Засаг дарга, САД, ЗДТГ-ын нягтлан бодогч	Ц.Төрхүү Г.Отгонцэцэг Т.Отгонцэцэг
	Дүн	90,779.3			